

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

ИНОВАЦИ ТӨСЛИЙН НЭГЖИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 06 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

НЭГ.БОДЛОГЫН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн засаг даргын шийдвэрийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газар, хот нийслэл, байгууллагаас дэвшүүлж буй зорилго, зорилтууд, , Нийслэлийн засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн засаг даргын захирамж, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт, байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудтай нэгжийн үйл ажиллагааг уялдуулан төлөвлөн ажиллаж байна.

ХАБЭА-н өдөр тутмын болон давтан зааварчилгааг мөрдөж ажлын байранд зөрчил доголдолгүй ажилласан.

Байгууллагын удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

2024 оны нэгжийн хөрөнгө материал сэлбэгийн жилийн эцсийн тооллогийг явуулан тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Нэгжийн нийт ажилтнуудын 2024 оны жилийн эцсийн үнэлгээг батлагдсан журмын дагуу хийн өгсөн.

Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх бохир усны шугам доторлогооны Теник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлаас Нийслэлийн Хот Байгуулалт Судалгааны институт татгалзаж байгаатай холбоотойгоор шинэ гүйцэтгэгч шалгаруулах,нэмэлтээр зөвлөхүүдийг татан ажиллуулах талаар Дэлхийн Банкны суурин төлөөлөгчид саналаа хүргүүлэв.

Туул -1 бохир усны коллекторын ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд БНХАУ-ын Хөх хотоос Улаанбаатар хот руу яндан хоолой зөөх тээврийн компаниудын судалгааг хийлээ.Үүнтэй холбогдуулан тээвэр болон хил гаалийн зардлын үнийн санал авсан.

Зургийн автороос яндан хоолойн ханган нийлүүлэлтийн үнийг хүссэн тул холбогдох тооцоог хийн ажлын хэсэгт танилцуулав

Лаг хатаах шатаах тайланг Барилгын хөгжлийн төвийн мэргэжлийн комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг ИБХ-тэй хамтран ажилласан.Нэмэлт мэдээлэлүүдээр хангаж дахин материал бүрдүүлэхээр ажиллаж байна.

Япон улсын TEPSCO компаний Шинэ Цэвэрлэх байгууламжийн гаргалгааны суваг,шугамын дагуу огтлолын зураг өгч тайлбар хийсэн.

БНХАУ-ын Шанхай хотын зураг төсвийн институтээс ирүүлсэн Лаг хатаах шатаах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийн орчуулгыг хянан Нийслэлийн Засаг даргын Тамгын Газарт өгсөн.

Шанхай хотод 6 сарын 3-7 хооронд болох үзэсгэлэнд УСУГ-аас оролцох хүмүүсийн жагсаалтыг удирдлагатай тохиролцон тушаалын төсөл,удирдамж бэлтгэсэн.

Удирдлагаас өгсөн үүргийн дагуу нэгжийн дүрмийг шинэчлэн боловсруулан удирдлагын зөвлөлийн гишүүдээр хянуулан зөвлөмж авч засч зөвлөлийн хурлаар батлууллаа.

Инженерийн бодлого төлөвлөлтийн даргаас өгсөн үүргийн дагуу байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс өөрийн нэгжид хамаарал бүхий заалтууд болон нэгжийн цаашдын төлөвлөлтөнд зайлшгүй байх ажлуудаас оруулан 2025 онд хийгдэх нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хяналтанд бэлэн болгосон.

Байгууллагаас өгсөн үүргийн дагуу сар бүр олгогддог нэмэлт цалингийн саналаа боловсруулан хяналтанд өгсөн.

Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хийгдэх бохир усны төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар шинэчлэн боловсруулж нийслэлийн захирагчийн ажлын албанд өгсөн.

Дэлхийн банкны Зүүн өмнөд Азийг хариуцсан захирал Сотомаяр болон бусад дагалдах мэргэжилтнүүдэд УСУГ, бохир усны шугамын талаархи ерөнхий мэдээллийг танилцуулсан.

Бохир усны шугам доторлогооны техник эдийн засгийн үндэслэлийн гадаад болон дотоодын зөвлөхүүдэд тавигдах шаардлагыг боловсруулан Нийслэлийн Захирагчийн ажлын албанд гаргаж өгсөн.

Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам болон тус улсаас ирсэн албаны 4 төлөөлөгчийг хүлээн авч УСУГ-ын Хяналт удирдлагын төвтэй танилцуулж, Газрын дарга Ц.Төрхүүтэй уулзуулан 6 сарын 13-ны өдөр манай байгууллагад ирж ажиллах 30 гаруй албаны хүмүүсийн айлчлалтай холбоотой бэлтгэл ажлын талаар ярилцсан.

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТАЛААР:

I. УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ, ШИНЭ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ БАРИХ ТӨСӨЛ


Одоо төслийн талбай дээр 240 хятад ажилтан, 100 орчим монгол ажилтан ажиллаж байна.

Шинэ Төв цэвэрлэх байгууламжийн барилга бүтээцийн ажил өнөөдрийн байдлаар 98

хувьд хүрсэн бол тоног төхөөрөмж суурилуулах ажил 85 хувьтай, технологийн 35 төрлийн

55 барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажил 91 хувьтай

үргэлжилж байна.



№	Шифр	Бохир ус цэвэрлэгээний байгууламжууд	Гүйцэтгэл
1	DC01	Том завсартай сараалж бай оролтын насосны станц /Ахуйн БУ-ы шугам/	90%

2	DC03	Нарийн сараалж ба агааржуулагчтай элс баригч	90%
3	DC04	Анхдагч тунгаагуурын хуваарилах камер /2 байгууламж/	100%
4	DC05	Анхдагч тунгаагуур болон лагийн сан, насосны станц /4 байгууламж/	70%
5	DC06	Өндөр хүчин чадалтай анхдагч тунгаагуур /Үйлдвэрийн БУ-ы шугам/	100%
6	DC07A	Аэротенк 1	90%
7	DC07B	Аэротенк 2	90%
8	DC08	Хоёрдогч тунгаагуурын хуваарилах камер болон лагийн насос станц /2 байгууламж/	100%
9	DC09	Хоёрдогч тунгаагуур /8 байгууламж/	98%
10	DC10	Гүн цэвэрлэгээний тунгаагуур	100%






№	Шифр	Лаг боловсруулах байгууламж	Гүйцэтгэл
18	DC20	Лаг өтгөрүүлэгчийн хуваарилах камер	100%
19	DC21	Лаг өтгөрүүлэгч /2 байгууламж/	70%
20	DC22	Лаг боловсруулах байгууламж	98%
21	DC23	Метантенк: ТБ бүтээцийн ажил	90%
22	DC23	Метантенк: Ган бүтээцийн ажил	100%
23	DC25	Хүхэргүйжүүлэгч	99%
24	DC26	Био хий хадгалах сав	55%
25	DC27	Био хий шатаах цамхаг	55%
26	DC28	Бойлер генераторын өрөө	99%
27	DC29	Лаг усгүйжүүлэх өрөө ба лагийн сан	98%

№	Шифр	Туслах барилга байгууламжууд	Гүйцэтгэл
11	DC11	Хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэх барилга	100%
12	DC12	Агааржуулах станц	98%
13	DC13	Урьдчилсан цэвэрлэгээний урвалж бэлтгэх өрөө	98%
14	DC14	Гүн цэвэрлэгээний урвалж бэлтгэх өрөө	98%
15	DC17	Бохир усны насосны станц	100%
16	DC18	Аваарийн сан	25%
17	DC19	Хаалт худаг	100%
28	DC41	Захиргааны барилга	95%
29	DC42	Засварын газар, агуулах, гараж	90%
30	DC44	Дэд станц 35/10kW	99%
31	DC46	Дэд станц №1	100%
32	DC47	Дэд станц №2	100%
33	DC48	Дэд станц №3	100%
34	DC49	Дэд станц №4	100%
35	DC50	Харуулын байр №1	100%
36	DC51	Харуулын байр №2	100%
38	DC53	Нэвтрэх суваг	100%
39	DC54	Дулаан хуваарилах төв	100%
40	DC56	Баруун дулаан хуваарилах төв	100%

41	DC55A	Үнэргүйжүүлэх систем А	98%
42	DC55B	Үнэргүйжүүлэх систем В	100%
43	DC55C	Үнэргүйжүүлэх систем С	100%
44	DC57	Орц гарцны ажил	90%

№	Шифр	Инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн барилга байгууламж	Гүйцэтгэл
37	DC52	Гаргалгааны суваг	94%
45		Байгууламжийн технологийн шугам хоолойн угсралтын ажил	73%
46		Дулааны шугам хоолойн угсралтын ажил	95%
47		Талбайн доторх зам талбай, гэрэлтүүлэг, гадна тохижилтын ажил	65%
48		Гадна цахилгаан хангамжийн ажил	90%
49		Холбоо мэдээллийн шилэн болон физик кабелийн сувагчлал, холболтын ажил	100%
50		Тоног төхөөрөмжийн татан авалт, угсралт болон туршилт тохируулгын ажил	50%

	<p>DC-11 дээр усны чанар шалгах удирдлагын төхөөрөмжүүд ирсэн бөгөөд суурилуултын ажил хийгдэж байна.</p>
	<p>Нээлттэй сувагт угсрагдсан цэвэр усны ба саарал усны шугам хоолойн усан туршилт.</p>
	<p>Биохийн бамбар /цогц/ байрлуулалт, биохийн DN300мм /SS304/ ган шугам хоолойн угсралт</p>

	<p>Метантенк, бойлер генераторын биохийн DN300мм шугам хоолойн угсралтын ажил</p>
	<p>Гадна ариутгах татуургын чиглэл зөрсөн DN1800мм төмөр бетон / ахуйн бохир усны/ шугам хоолойд нэмэлт худаг цутгах ажил.</p>
	<p>DN1500мм, DN1800мм шугам хоолойн худгийн ховил, ажлын талбайн өнгөлгөө шавардлагын ажил</p>
	<p>Ахуйн болон үйлдвэрийн бохир усны флокулянтын дозлогч насосны шугам хоолой хэмжих хэрэгслийн угсралт</p>
	<p>DC03 нарийн сараалжтай агааржуулалттай элс баригчийн оролтын ган DN1400мм, DN1600мм шугам хоолойн урьдчилсан усан туршилтын ажил.</p>
	<p>Хэрэглээний халуун усны өгөх буцах цайртай доторлогоотой ган шугам хоолой угсрах бэлтгэл ажил. Ажлын зурагт тусгагдаагүй нэмэлтээр гүйцэтгэгдэнэ. /Захиргаа, засвар гражийн барилга/</p>

		<p>Үнэргүйжүүлэлтийн сан угсрагдаж байна. Материал шилэн хавтан нааж угсарсан.</p>	
		<p>Дулааны зүүн төв тоноглол, шугам хоолойн угсрагдсан тохиргоо хийгдэнэ.</p>	
			<p>Ахуйн бохир усны анхдагч тунгаагуурын мембрам дээврийн металл бүтээц, мембрам угсралтын ажил.</p>
		<p>DC07B биореактор-аэротенкийн гадна дулаалгын ажил.</p>	
			<p>Лаг усгүйжүүлэх байгууламжийн шугам хоолойн угсралтын ажил</p>
		<p>Гадна талбайн замын ажил.</p>	

	<p>Гүн цэвэрлэгээ, урвалжийн байгууламжийн химийн /ABS/ маркийн шугам хоолойн угсралтын ажил.</p>
	<p>Боилер генераторын шугам хоолой, дагалдах хэрэгслийн угсралтын ажил</p>
	<p>DC07B биореактор-аэротенкийн диффузорын шугам хоолой угсрах ажил, мөн холигч угсарсан байдал</p>

Цэвэрлэгдсэн бохир усыг дахин боловсруулах үйлдвэрийн ажлын явц


Цэвэрлэх байгууламжаас гарч байгаа бохир усыг дахин боловсруулах үйлдвэрийн төсөл дээр ажиллаж байсан гүйцэтгэгч компаниудын ажил

5 сарын байдлаар :

- Захиргааны барилга-79%
- Насосны станц-1-85%
- Ус дамжуулах төв-80%
- MBBR-72%
- Ламилла тунгаагуур-72%
- Ширхэгч дүүргэгчтэй шүүлтүүр-62%
- Халдваргүйжүүлэх сан -88%
- Тогтворжуулах сан-83,71%
- Насосны станц-2-75%
- Цахилгаан төхөөрөмжүүдийн цуглуулбар-2- 60%
- Цахилгаан төхөөрөмжүүдийн цуглуулбар-3-73%
- Ус зайлуулах насосны станц-61%
- Цахилгаан төхөөрөмжүүдийн цуглуулбар-3-100%
- Технологийн усны худаг - 41%
- Цахилгаан төхөөрөмжүүдийн цуглуулбар-4-30%
- Хлор бэлтгэх байгууламж-10%

Технологийн шугам сүлжээний нийт урт: 3,411 м
Угсралтын ажил бүрэн дууссан.

Хаягдал усны шугам сүлжээ: 3,571.5 м
Ажлын гүйцэтгэл: 95% (2025 оны 4-р сарын байдлаар)




- Хаягдал усны шугам
- Технологийн усны шугам

2019.08.28-ны өдөр 22 га газрыг аюултай хог хаягдал, лаг булшлах, устгах байгууламжийн зориулалтаар ЗГ-аас олгохоор шийдвэрлэсэн. Мянганы сорилтын сангийн **"Лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөө"** боловсруулагдаж байна.

Шинэ төв цэвэрлэх байгууламжаас гарах лагийг хуучин цэвэрлэх байгууламжийн лагийн **15 картад** түр хугацаанд хадгалахаар төлөвлөж байна.

"Лаг шатаах үйлдвэрийг шинээр барих төсөл"-ийн ТЭЗҮ-г шинэчлэх ажил хийгдэж байна.



Хийгдэж байгаа томоохон ажлуудаас дурдвал:

 <p>28 Apr 2025 09:01:58</p>	<p>Үйлдвэрлэлийн барилга 70%-тай тоног төхөөрөмжийн суурилуулалт 75% байна.</p>
 <p>28 Apr 2025 09:02:04</p>	<p>Өргөлтийн насосны станцын №1 ажил 75 %</p>
 <p>20 May 2025 13:45:49 20 May 2025 13:46:24</p>	<p>Хөдөлгөөнт био реакторын, coagulation, flocculant, lamella тунгаагуурын станц агааржуулах хоолойн, халуунаар үлээгч калорифер угсрагдаж байна.</p>
 <p>20 May 2025 13:46:52 20 May 2025 13:48:02</p>	<p>Ламелла тунгаагуурын тунасан лаг сорох ,хаягдал ус шахах насосын холболтын ажил хийгдэж байна</p>
 <p>20 May 2025 13:58:49 20 May 2025 14:00:04 20 May 2025 13:59:44</p>	<p>Агаар өгөх компрессорын өрөө, цахилгаан үүсгэвэрийн генераторын өрөөнд хана таазны будаг эмульс хийгдэж байна.</p>
 <p>20 May 2025 14:03:30 20 May 2025 14:05:44 20 May 2025 14:08:32</p>	<p>Хөдөлгөөнт био реакторын станцаас олон үет шүүлтүүрийн станц руу ус дамжуулах шугам хоолойн ажил хийгдэж байна.</p>

 <p>20 May 2025 14:11:18 SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	 <p>20 May 2025 14:13:18 Tovchoo Road SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	<p>Олон үет шүүлтүүрийн станцад усан тест болон хаалт арматур угсрах ажил хийгдэж байна.</p>
 <p>20 May 2025 14:22:44 Tovchoo Road SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	 <p>20 May 2025 14:26:59 Tovchoo Road SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	<p>Олон үет шүүлтүүрийн станц руу ус болон агаар өгөх шугам хоолойн ажил хийгдсэн байдал. Цахилгааны ажил хийгдэнэ.</p>
 <p>20 May 2025 14:33:50 Tovchoo Road SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	 <p>20 May 2025 14:37:58 Tovchoo Road SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	<p>Цахилгаан хлоржуулалт, Цахилгааны дэд станцын барилгын ажлын явц.</p>
 <p>20 May 2025 14:39:18 SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	 <p>20 May 2025 14:39:22 SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	<p>Өргөлтийн насос станц №2-н сорох шугам хоолойн болон цахилгаан тэжээлийн, агааржуулах хоолойн ажил хийгдэж байна.</p>
 <p>20 May 2025 14:42:27 SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	 <p>20 May 2025 14:42:31 SHD - 20 khoroo Songino Khaikhan Ulaanbaatar</p>	<p>Химийн агуулах болон засвар цехийн станцын газар шороо, багана цутгалтын ажил хийгдэж байна.</p>


II. МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН ТӨСӨЛ БАНУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ТАЛААР

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн нийт барилга угсралтын ажлын явц

- Үйлдвэрийн гадна талбайн ажлын гүйцэтгэл **30%**
- Ус гүн цэвэршүүлэх барилгын угсралтын ажлын гүйцэтгэл: **96%**
- Урвуу осмосын барилгын угсралтын ажлын гүйцэтгэл **100%**
- Цэвэршүүлсэн усны сан,насос станцын барилгын угсралтын ажлын гүйцэтгэл **100%**
- Хаягдал боловсруулах барилгын угсралтын ажлын гүйцэтгэл **100%**
- Цахилгааны барилгын угсралтын ажлын гүйцэтгэл **100%**

- Харуулын барилгын угсралтын ажлын гүйцэтгэл **100%** тус тус байна.


Урвуу осмосын цэвэрлэгээний төхөөрөмжүүд




Насос тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын явцаас




Биокомбинатын дамжуулах шугамын угсралт



Биокомбинатын гүний худгуудын угсралтын явц




Дамжуулах шугамын гол хөндлөн гарсан хэсэгт хийсэн өрөмдлөгөөний ажлын ажлын явц




Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн ажилтнуудын сургалт



Ус сувгийн удирдах газраас алба хэлтсүүдээс нийт 25 ажилтан графикт сургалтанд хамрагдсан.




Биокомбинатын 2,8,11,14-р худгуудын шугамын холболтын хаалт тоног төхөөрөмжийн ажлууд хийгдэж байна.



Шувуун фабрикийн 16 гүний худгуудын цуглуулах шугамын ажлыг Монкон компаний туслан гүйцэтгэгч компаний ажилтнууд шугам дээрх цахилгаан хаалтууд угсарч тоноглох, худгийн барилгын ажлыг гүйцээж дуусгах, салбар шугамыг холбох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Биокомбинатын гүний усны дамжуулах шугамын голын салаа доогуур сүвлэх ажлыг Эрдэнэдрилинг компаний хятад мэргэжилтэнгүүд ирснээр сүвлэгээний ажлыг явуулж байна.

Цуглуулах шугамын гол доогуур сүвлэх ажлын гүйцэтгэгч Эрдэнэдрийлэнг ХХК ажлын бэлтгэлийг 3 удаа танилцан зураг авч баримтжуулан ИТН-н ажилтнуудад өгсөн ба эхний өрөмдлөгийн байршилд 4 дугаар сарын 20-ны байдлаар 210м шугам суулгахаас 240 м футляр шугамын сүвэлгээг хийж дуусгасан бөгөөд зэрэгцээ футляр шугамын сүвэлгээний ажил 240 м өрөмдлөгийн ажил хийж дуусгаад дараагийн өрөмдлөгөөний хэсэг рүү шилжсэн.





III. УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нь 2025 оны 3 сарын 31-ны байдлаар 66.78% байна. Дараах хүснэгтээс үе шат бүрээр хэрэгжилтийг харна уу

Үйл ажиллагаа	Бодит явц
ТУН байгуулах	100.00%
1 дүгээр үе шатны үйл ажиллагаа	100.00%
2 дугаар үе шатны үйл ажиллагаа	60.85%
3 дугаар үе шатны үйл ажиллагаа	38.91%
Төслийн хаалт	0.00%
Хөтөлбөр	66.78%

IV. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД

Ус ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Нидерланд улсын ВЭИ компаниас 2025 оны 5 сарын 4-нөөс 5 сарын 21-ний өдрийг дуустал 11 ажилтан УСУГ дээр өөрсдийн чиглэлийн хүрээнд алба хэлтсүүдийн инженер техникийн ажилтнуудтай багаараа ажиллаа.



ВЭИ компанийн мэргэжилтнүүд УСУГ-ын ажилтнуудад сургалт зохион байгуулах, төслийн багууд хамтран ажиллаж тайлангаа танилцуулах, 2025 онд зохиогдох сургалт аяллын болон бусад ажлын төлөвлөгөөг хэлэлцэх, шинэ Төв цэвэрлэх байгууламж, Ус гүн

цэвэршүүлэх, Хаягдал ус дахин боловсруулах байгууламжуудын барилга угсралтын ажлын төслийн талбай дээр очиж танилцах чиглэлээр хамтран ажилласан.

5 сарын 16-ны өдөр МСС, ВЭИ, УСУГ-ын хамтарсан дүгнэх уулзалтыг зохион байгуулж, ВЭИ компанийн экспертүүд болон УСУГ-ын багийн ахлагч нар оролцон ажлын тайланг хэлэлцлээ. Мэргэжилтнүүдийг ажиллах үед экспертүүдийг нисэх онгоцны буудлаас тосох, гаргаж өгөх, уулзалтууд болон төслийн ажлуудтай газар дээр нь танилцуулах ажлыг зохион байгуулсан.

Токио хотын ариутгах татуургын үйлчилгээний корпорацитай хамтран хэрэгжүүлж буй “Ариутгах татуургын шугам хоолойн засвар үйлчилгээ, удирдлага, шинэчлэлтийг хийх, УСУГ-ын хүний нөөцийг хөгжүүлэх” төслийн хүрээнд TGS компанийн мэргэжилтнүүдэд шаардлагатай ГМС-ийн өргөтгөл шинэчлэлт хийгдсэн програмын гарын авлага, бохир усны шугамын камерын оношилгоог хийх төлөвлөгөөг хүргүүлж, Баянзүрх болон Баянгол дүүргийн шугамын мэдээллийн тодруулгыг явуулсан.



Төслийн хэрэгжилттэй холбоотой ЖАЙКА-ийн Төв оффисоос Ерөнхий захирал Конч Кеничи, хөтөлбөрийн ажилтан Кимура Рёоко, Монгол дахь ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн Газраас Суурин төлөөлөгч Ватарай Хирока, хөтөлбөрийн ажилтан Оюунцэцэг нар ирж байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, сургалтад хамрагдсан ажилтнуудын төлөөлөлтэй уулзсан.

Бусад ажлын хүрээнд:

Байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу нэгж нь Инженерийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн бүтцэд харьяалагдан төв оффисийн 7 давхрын 706 өрөөнд шилжин үйл ажиллагаа үргэлжлүүлж байна.

ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ:

3.1 Хүний нөөцийн бодлогын ил тод байдал.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 1 менежер, 4 инженерийн орон тоотойгоор ажиллаж байна.

ДӨРӨВ. ШИНЭ САНААЧЛАГЫН ҮР ДҮН:

4.1 Байгууллагаас зохион байгуулсан соёл, олон нийтийн ажил, уралдаан тэмцээнд амжилтнуудаа хамруулсан байдал үр дүн:

4.1 Байгууллагаас зохион байгуулсан соёл, олон нийтийн ажил, уралдаан тэмцээнд амжилтнуудаа хамруулсан байдал үр дүн:



Татварын Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтанд нэг ажилтан хамрагдсан.



Нийслэлийн үйлдвэрчний эвлэлийн холбоодын бага хуралд Г.Мөнгөнцэцэж хамрагдсан.



Хөдөлмөрийн аюулгүй байдлын сарын хүрээнд хийсэн ажлын товч тайлангийн хуралд Ш.Ганзориг хамрагдсан.



5 сарын 24-нд зохиогдсон Олон улсын марафон гүйлтэнд төслийн инженер Ш.Ганзориг 5 км зайд амжилттай оролцсон.



Байгууллагын хэмжээнд Нөлөөллийн аяны хүрээнд зохион байгуулагдсан “Уучлалын өдөр” арга хэмжээг явуулсан.

Байгууллагаас зохион байгуулсан соёл, олон нийтийн ажил, уралдаан тэмцээнд амжилтнуудаа хамруулсан байдал үр дүн:



Сүхбаатарын талбай дээр зохион байгуулагдсан олон улсын циркийн тоглолтыг үзэж сонирхлоо.



2 сард болсон улсын аварга шалгаруулах хөлбөмбөгийн тэмцээнд төслийн инженер Ш.Ганзориг Эрчим багийн бүрэлдхүүнд хамрагдан Алтан медаль,Цомоор шагнуулсан.



4 сард болсон Мастер ангилалын тамирчдын Сансар-2025 хөлбөмбөгийн тэмцээнд төслийн инженер Ш.Ганзориг Эрчим багийн бүрэлдхүүнд хамрагдан цом,Өргөмжлөл, Алтан медаль,мөнгөн шагналаар шагнуулсан.

ШИНЭ САНААЧЛАГЫН ҮР ДҮН:



Гадуур шалгалтын ажлаар явахдаа авч хэрэгжүүлж болохуйц ХАБ-н талаархи авч хэрэгжүүлж болохуйц шинэ санааг олж харлаа.

Энэ нь цэвэр ба бохирын шугам хоолойн ажил хийж байх үедээ ажил явуулж байгаа шугамын гадна ажил гүйцэтгэж байгаа ажлын болон ажилчдын талаархи мэдээллийг тусгасан самбар байлаа. Энэ мэдээлэлд шуудуу сувагт хэдэн ажилчин өдрийн болон оройн цагаар ажиллаж буй талаар мэдээлэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын санамж бүс шат зэргийг байрлуулсан гэрэл гэрэлтүүлэг байрлуулсан зэрэг санаа авахуйц зүйлүүд байлаа.

Инженер Ш.Ганзориг нь Цэвэрлэх байгууламжийн лагнаас дээж авч бактертай уусмал цацан лаг үнэргүйжүүлэх туршилт хийж байна.



ТАВ.ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

5.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал.

"АЖИЛТНУУДЫН ҮНДСЭН БА НЭМЭГДЭЛ ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН 2025 ОНЫ ТООЦОО"-г гаргаж ЭЗСБХ-т хугацаанд нь хянуулж батлуулсаны дагуу зарцуулж ажилласан.

2025 оны эхний хагас жилд Нэгжийн ажилтнуудыг ээлжийн амралтын хуваарийн дагуу дөрвөн ажилтанг амрааж, ээлжийн амралтын мөнгийг журмын дагуу олгож ажилласан.

Ашиглаж байгаа 1'861.3 мянган төгрөгийн бараа материал, 8'467.1 мянган төгрөгийн биет үндсэн хөрөнгө, 320.0 мянган төгрөгийн биет бус үнсэн хөрөнгийн тус тус үлдэгдэлтэй байна.

2024 оны жилийн эцсийн тооллогоор ашиглалтаас хасуулахаар санал оруулсан 5 ш хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 05 сарын 2-ны өдрийн А/75 тоот тушаалыг үндэслэн зөвшөөрсний дагуу 5-р сард ашиглалтаас хасч бүртгэсэн.

Тайлант хугацаанд дансны авлага, өглөггүй ажилласан боловч ХХОАТ-ын шинэчлэгдсэн хууль хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажилтан бүрийн цалин хөлснөөс цалингын шатлалаар тооцон авах журмын дагуу ХХОАТ-ын авлага 86.0 мян.төг, өглөг 43.9 мян.төг-ийн дансны бичилт хийгдсэнийг 2025 оны 1 дүгээр сарын цалин олгоход тооцон барагдуулсан болно.

Байгууллагын 2025 онд зарцуулах зардлын төлөвлөгөөний дагуу Иноваци төслийн нэгжийн зардлын сарын хуваарилалтыг гарган Санхүү бүртгэлийн хэлтсээр батлуулан мөрдөж ажилласан.

2025 оны зардлын гүйцэтгэлийг шинжилж харахад хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, зардлыг хэтрүүлэлгүй ажилласан байна.

УСУГ –ын даргын 2025 оны 05-р сарын 27-ны өдрийн А/138 тоот тушаалын дагуу Иноваци төслийн нэгж нь 2025 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг Менежерийн болон ИТА ажилтнуудын өрөөнд бүртгэлтэй эд хөрөнгийг тухайн ажилтан албан хаагчийг байлцуулан “Цахим тооллого” нэг бүрчлэн тоолж илтгэх хуудас бичин Санхүү бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгийн нягтлан бодогчид тайланг хүргүүлж ажилласан.

Хангамжийн хэлтсээс хүлээн авсан бичиг хэргийн материал, ХАБЭА-н зуны хувцасыг захиалгын дагуу ажилтнуудад бүрэн олгосон.

Инновац, төслийн нэгж нь 2025 оны эхний хагас жилд /5,6-р сарын ХБГ-ээр/ 16 төрлийн зардалд нийт 237'417.8 мян.төг-ийн зардлын төлөвлөгөөтэй ажилласнаас 236'110.8 мян.төг зарцуулж 1'307.0 мян.төг хэмнэсэн байна.

Нэгжийн нягтлан бодогч нь дотоод сургалтын төлөвлөгөөнд төлөвлөгдсөний дагуу Хөрөнгийн үнэлгээчин бэлтгэх цахимаар болон танхимын хосолсон сургалт, Ёс зүйн сургалтанд суралцсан.

УСУГ-ын санхүү бүртгэл, эдийн засгийн ажилтнуудын зөвөлгөөнд оролцсон. ММНБИ-ээс зохион байгуулсан үндсэн хөрөнгийн сүртгэлийн сургалтанд мөн хамрагдсан.

ЗУРГАА. ХАРИУТАЙ АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Тайлант улиралд ирсэн бичиг 11, явсан бичиг 6, хариутай албан бичиг 5 байсан ба цаг хугацаанд нь шийдвэрлэн ажиллсан.

ХЯНАСАН:

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН МЕНЕЖЕР

А.ОРГИЛТ

ТАЙЛАН НЭГТГЭН БИЧСЭН:

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ИНЖЕНЕР

Ц.БАЯРАА